



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 03 сарын 03 өдөр

Дугаар 22

Улаанбаатар хот

Шуурхай штабыг шинэчлэн байгуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27<sup>1</sup> дугаар зүйлийн 27<sup>1</sup>.1.4, 27<sup>1</sup>.1.6, 28 дугаар зүйлийн 28.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх чиглэлээр Засгийн газар, Улсын онцгой комиссоос гарсан шийдвэрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах, хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий Шуурхай штабын ажиллах түр журмыг нэгдүгээр, Шуурхай штабын бүтцийг хоёрдугаар, Шуурхай штабын бүрэлдэхүүнийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Шуурхай штабт үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчдын үндсэн ажил, үүргийг зохицуулж, цалин хөлс, урамшуулал, илүү цагийн нэмэгдэл хөлс, хууль, тогтоомжийн дагуу тооцож олгохыг холбогдох байгууллагуудын төсвийн захирагч нарт даалгасугай.

3. Шуурхай штабын үйл ажиллагааг бодлогын удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Улсын онцгой комиссын орлогч дарга Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаярт, өдөр тутмын шууд удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, бригадын генерал Г.Ариунбуянд тус тус үүрэг болгосугай.

4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Улсын онцгой комиссын даргын “Шуурхай штаб байгуулах тухай” 2020 оны 06, Монгол Улсын Шадар сайдын “Шуурхай штаб байгуулах тухай” 2020 оны 137 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



С.АМАРСАЙХАН

## УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ШУУРХАЙ ШТАБЫН АЖИЛЛАХ ТҮР ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахал (цаашид “Цар тахал” гэх)-аас урьдчилан сэргийлэх, тэмцэх хариу арга хэмжээг удирдлага, зохион байгуулалтаар хангах Улсын онцгой комиссын Шуурхай штаб (цаашид “Шуурхай штаб” гэх)-ын үйл ажиллагааг зохицуулах, эрх, үүргийг тогтооход оршино.

1.2. Шуурхай штаб нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр Улсын Их Хурал, Засгийн газар, Улсын онцгой комиссоос гаргасан тогтоол, шийдвэр, Олон улсын эрүүл мэндийн дүрэм, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийг мөрдлөг болгож ажиллана.

1.3. Шуурхай штабын бүтэц, бүрэлдэхүүнийг Улсын онцгой комиссын дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн Онцгой комиссын Шуурхай штабын бүтэц, бүрэлдэхүүн, ажиллах журмыг энэхүү журамд нийцүүлэн тухайн шатны Онцгой комиссын дарга батална.

1.4. Шуурхай штаб нь үйл ажиллагаа явуулах хугацаандаа Улсын онцгой комиссын Шуурхай штабын нэр бүхий албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг ашиглана.

### Хоёр. Шуурхай штабын удирдлага, зохион байгуулалт, бүтэц

2.1. Улсын онцгой комиссын дарга Шуурхай штабыг бодлого, стратегийн удирдлагаар хангана.

2.2. Шуурхай штабын өдөр тутмын үйл ажиллагааг штабын дарга удирдан зохион байгуулж, Улсын онцгой комиссын орлогч дарга хяналт тавина.

2.3. Шуурхай штаб нь Онцгой байдлын ерөнхий газрын байранд үйл ажиллагаагаа явуулах бөгөөд ажлын цагийн хуваарийг Онцгой байдлын ерөнхий газрын дарга батална.

2.4. Шуурхай штаб нь хүн амын эрүүл мэнд, улс орны нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, Улсын онцгой комиссын дэргэдэх эрдэмтдийн зөвлөлийн гаргасан зөвлөмж, эрсдэлийн үнэлгээний дүгнэлт зэргийг харгалзан, аймаг, нийслэлийн Онцгой комисстой үйл ажиллагаагаа уялдуулж, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, чиглүүлж ажиллана.

2.5. Шуурхай штабын бүрэлдэхүүнд гамшгаас хамгаалах улсын алба, тусгай чиг үүрэг бүхий болон холбогдох төрийн байгууллагын мэргэжлийн, шийдвэр гаргах түвшний албан хаагч, Монголын улаан загалмай нийгэмлэгийн төлөөллийг ажиллуулна.

2.6. Шуурхай штаб нь дарга, орлогч, нарийн бичгийн дарга, хяналт шалгалтын болон хэвлэл мэдээлэл хариуцсан хэсэг, хариу арга хэмжээг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажиллагаа-зохицуулалт, бүс, орон нутгийн зохицуулалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ, төлөвлөлт, нөөц-хангалт, мэдээллийн технологи, харилцаа холбоо, захиргаа-санхүүгийн баг (цаашид “Шуурхай штабын багууд гэх”)-аас бүрдэнэ.

2.7. Шуурхай штабын даргын дэргэд улс орны нийгэм, эдийн засгийн бодлогын асуудал хариуцсан болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, тандалт, эрсдэлийн асуудал хариуцсан зөвлөх, эрдэмтдийн баг, яамдын дэд сайд нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ажиллаж, мэргэжил арга зүй, бодлогын дэмжлэг үзүүлнэ.

2.8. Хариу арга хэмжээг зохион байгуулах багууд дараах үйл ажиллагааг зохион байгуулна.

2.8.1. Ажиллагаа-зохицуулалтын баг:

- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, халдварын сэргийлэлтийн үйл ажиллагаа
- Татан авалтын үйл ажиллагаа
- Хил, хилийн боомт нэвтрүүлэх үйл ажиллагаа
- Иргэний болон ажиллах хүчний бүртгэл, хяналтын үйл ажиллагаа
- Тусгаарлан ажиглах үйл ажиллагаа

2.8.3. Бүс, орон нутаг хариуцсан баг:

- Бүс, орон нутгийн зохицуулалтын үйл ажиллагаа

2.8.4. Хяналт-шинжилгээ, үнэлгээний баг:

- Дүн, шинжилгээний үйл ажиллагаа

2.8.5. Төлөвлөлтийн баг:

- Эрсдэлийн үнэлгээ, төлөвлөлтийн үйл ажиллагаа
- Мэдээ, судалгааны үйл ажиллагаа

2.8.6. Нөөц, хангалтын баг:

- Эм, эмнэлгийн хэрэгсэл, хүний нөөцийн бүртгэл, судалгаа
- Хүнс, бараа, материалын нөөцийн бүртгэл, судалгаа

2.8.7. Мэдээллийн технологи, харилцаа холбооны баг:

- Мэдээллийн технологийн үйл ажиллагаа
- Харилцаа холбооны үйл ажиллагаа
- Орон зайн дүн шинжилгээний үйл ажиллагаа

2.8.8. Захиргаа, санхүүгийн баг:

- Захиргаа, санхүү, аюулгүй байдлын үйл ажиллагаа
- Өргөдөл, гомдол, бичиг хэрэг, тайлан, архивын үйл ажиллагаа

2.9. Шуурхай штабын авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, гарсан шийдвэр, иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод байна.

2.10. Шуурхай штабын үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, бүрэлдэхүүний нэр, хариуцсан ажил, холбогдох утсыг [zasag.mn](http://zasag.mn) цахим хуудасны

“Монгол Улс дахь COVID-19-ын талаар дэлгэрэнгүй мэдээ, мэдээлэл” хэсэгт нээлттэй байршуулна.

### **Гурав. Шуурхай штаб, штабын дарга, орлогч, нарийн бичиг, хяналт шалгалтын болон хэвлэл мэдээллийн хэсгийн эрх, үүрэг**

#### **3.1. Шуурхай штаб дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:**

3.1.1. Засгийн газар, Улсын онцгой комиссын шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, шуурхай зохион байгуулах, хяналт тавих, тайлагнах;

3.1.2. Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх хариу арга хэмжээг хүн амын эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан төлөвлөж зохион байгуулах;

3.1.3. Эм, эмнэлгийн хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний нөөцийн судалгааг гаргах, хангалтыг зохицуулах;

3.1.4. Улсын онцгой комисс, Гамшгаас хамгаалах улсын алба, бүсийн төвүүд болон аймаг, нийслэлийн Онцгой комиссын үйл ажиллагааг уялдуулах, мэдээ, мэдээллийг цахим технологийн түвшинд шуурхай солилцох;

3.1.5. Халдварын нөхцөл байдлын эрсдэлийн үнэлгээг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран тогтмол үр дүнтэй хийх;

3.1.6. Иргэдийн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, хариу өгөх арга хэмжээг хуулийн хугацаанд шуурхай зохион байгуулах;

3.1.7. Гадаад харилцааны яам, хилийн чанад дахь Дипломат төлөөлөгчийн газрууд болон Улаанбаатар хот дахь Дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагуудтай тогтмол мэдээлэл солилцох;

3.1.8. Нийслэл Улаанбаатар хотоос гарах, орох албан томилолт, ар гэрийн гачигдал, оршуулгын үйл ажиллагаатай холбоотой зөвшөөрлийг аймаг, нийслэлийн Онцгой комиссын шуурхай штаб холбогдох журмын дагуу олгоно;

3.1.9. Шуурхай штабын үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх.

#### **3.2. Шуурхай штабын дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:**

3.2.1. Шуурхай штабын үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалтаар хангах, холбогдох түр журам, заавар батлах;

3.2.2. Шуурхай штабын багуудын үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан гүйцэтгэлд хяналт тавих;

3.2.3. Шуурхай штабын бүрэлдэхүүн, бүсийн төвийн болон орон нутгийн шуурхай штабуудад үүрэг, чиглэл өгөх, биелэлтийг хангуулах, хяналт тавих;

3.2.4. Шуурхай штабын үйл ажиллагааны тайлан, хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг сар тутам Улсын онцгой комисст танилцуулах;

3.2.5. Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, Улсын онцгой комиссын шийдвэрийн хэрэгжилтийг тухай бүр Улсын онцгой комисст тайлагнах;

3.2.6. Улсын онцгой комиссын дарга, орлогч дарга, гишүүд болон холбогдох албан тушаалтныг мэдээ, мэдээллээр хангах;

3.2.7.Хоногийн нөхцөл байдлын мэдээ, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар Монгол Улсын Шадар сайдын зөвлөх, Улсын онцгой комиссын орлогч дарга, Улсын онцгой комиссын нарийн бичгийн даргад өдөр тутам танилцуулах;

3.2.8.Хэрэгжүүлэх арга хэмжээнээс хамаарч Шуурхай штабын бүрэлдэхүүний ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, ээлжийн зохион байгуулалтад оруулах, ажлын цагийн зохицуулалт хийх, шаардлагатай бусад зохион байгуулалтын арга хэмжээ авах.

### 3.2.9.Бусад

3.3.Шуурхай штабын орлогч дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.3.1.Шуурхай штабын даргын өгсөн үүргийн хэрэгжилтийг хангах, Шуурхай штабын багуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, өдөр тутам хяналт тавих;

3.3.2.Шуурхай штабын багуудын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг хянах, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар Шуурхай штабын даргыг мэдээллээр хангах;

3.3.3.Халдварын нөхцөл байдалтай холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, Шуурхай штабын багуудын тавьсан санал, хүсэлт, шийдвэрлэх асуудлыг Шуурхай штабын даргад танилцуулж шийдвэрлүүлэх;

3.3.4.Шуурхай штабын бүрэлдэхүүний ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, ажил, амралтын цагийг зохицуулах, эрүүл мэндийг хамгаалах, халдвар хамгааллын дэглэмийг сахиулах;

3.3.5.Засгийн газар, Улсын онцгой комиссын тогтоол, шийдвэрийн төсөл, Шуурхай штабын тайлан, Улсын онцгой комисс болон олон нийтэд хүргэх мэдээ, мэдээллийг хянаж, Шуурхай штабын даргад хүргүүлэх;

3.1.6.Улсын онцгой комисс, иргэд, олон нийтийг цар тахлын нөхцөл байдал, түүний эсрэг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдээ, мэдээллээр хангах;

3.3.7.Шуурхай штабын бүрэлдэхүүний сахилга, хариуцлага, ажилласан цагийн тооцоо, ажил үүргийн гүйцэтгэлтэд хяналт тавих.

### 3.3.8.Бусад

3.4.Нарийн бичгийн дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.4.1.Засгийн газар, Улсын онцгой комиссын шийдвэрийн төсөл боловсруулах, гарсан шийдвэрийн бүртгэлийг хөтлөх, Шуурхай штабын үйл ажиллагааны танилцуулга бэлтгэх;

3.4.2.Шуурхай штабын дарга, орлогч нарт дотоод ажлын зохион байгуулалтад дэмжлэг үзүүлж ажиллах;

3.5.Хяналт шалгалтын хэсэг дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.5.1.Монгол Улсын Шадар сайдын баталсан удирдамжийн дагуу төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт, шалгалтыг улсын хэмжээнд зохион байгуулах

3.5.2.Бүх шатны онцгой комиссын шуурхай штабын үйл ажиллагаанд хяналт тавих;

3.5.3.Ажиллагаа, зохицуулалтын багийн үйл ажиллагаанд хяналт тавих, холбогдох объектуудад хяналт шалгалт зохион байгуулах;

3.5.4.Хяналт шалгалтын үр дүн, тайланг Шуурхай штабын дарга, Шадар сайдын зөвлөхөд танилцуулах, заавар чиглэл авах;

3.5.5.Шуурхай штабын багуудын төлөвлөлт, биелэлтийг хянах, чиглэл өгөх, уялдаа холбоог хангах талаар санал боловсруулж, штабын даргад танилцуулах;

3.5.6.Удирдлагаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу болон мэдээллийн мөрөөр хяналт, шалгалтыг газар дээр нь зохион байгуулах;

3.5.7.Хяналт шалгалтын талаарх олон нийтэд хүргэх шаардлагатай мэдээ, мэдээллийг бэлтгэн Хэвлэл, мэдээллийн хэсэгт хүргүүлэх.

3.6.Хяналт шалгалтын хэсэг дараах чиглэлээр хяналт шалгалт зохион байгуулна:

3.6.1.Гадаад улс орноос иргэдийг татан авах болон хилийн боомтын нэвтрүүлэх үйл ажиллагаа;

3.6.2.Тусгаарлан ажиглах байрны нөхцөл байдал, халдвар хамгааллын дэглэмийн хэрэгжилт, томилогдон ажиллаж буй албан хаагчдын үүрэг гүйцэтгэлт;

3.6.3.Шалган нэвтрүүлэх товчоо, хөдөлгөөний хязгаарлалтын үйл ажиллагаа;

3.6.4.Коронавирусын халдвар (Ковид-19)-тай холбоотой бүх шатны онцгой комисс, байгууллагын хүнс, бараа материал, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөц бүрдүүлэлт, хангалт, тэдгээрийн чанар, стандартын шаардлагад нийцэж буй байдал;

3.6.6.Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт.

3.7. Хэвлэл, мэдээллийн хэсэг дараах үүргийг хэрэгжүүлнэ:

3.7.1.Улсын онцгой комисс, Шуурхай штабын авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар олон нийтэд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хүргэх;

3.7.2.Мэдээ, мэдээллийг иргэд, олон нийтэд ойлгомжтой, товч, тодорхой бэлтгэж, [zasag.mn](http://zasag.mn) цахим хуудасны “Монгол Улс дахь COVID-19-ын талаар дэлгэрэнгүй мэдээ, мэдээлэл” хэсэгт байршуулж нэг сувгаар хүргэх;

3.7.3.Бэлтгэсэн мэдээ, мэдээллийн төслийг Шуурхай штабын орлогчид танилцуулж, үүрэг, чиглэл авах;

3.7.4.Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр түгж байгаа мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, шаардлагатай тохиолдолд залруулга хийх;

3.7.5.Иргэдээс ирүүлж буй өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, Хяналт шалгалтын хэсгийн тайлан мэдээнд үндэслэн мэдээ, мэдээллийг бэлтгэх, түгээх;

3.7.6.Шуурхай штабын хэвлэлийн бага хурал, цахим хурал зохион байгуулах.

## **Дөрөв. Шуурхай штабын багуудын чиг үүрэг**

### **4.1. Шуурхай штабын багуудын ахлагч дараах үүргийг хэрэгжүүлнэ:**

4.1.1. Багийн үйл ажиллагааг сараар төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, хянах, гүйцэтгэлийг Шуурхай штабын даргад тайлагнах;

4.1.2. Багийн үйл ажиллагааг өдөр тутам удирдан зохион байгуулах, үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг хангах, заавар, зөвлөмж өгөх;

4.1.3. Багийн тогтвортой ажиллагааг хангах, гишүүдийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, ажлын хариуцлага, дэг журмыг сахиулах;

4.1.4. Багийн гишүүдийн үйл ажиллагаа явуулах нөхцөл боломжийг бүрдүүлэх, тэдний эрүүл мэндийг хамгаалах, халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиулах;

4.1.5. Багийн үйл ажиллагааны талаар Шуурхай штабын дарга, орлогчийг мэдээ, мэдээллээр тогтмол хангах;

4.1.6. Штабын даргын өгсөн үүрэг, даалгавар, шийдвэрийн хэрэгжүүлж, биелэлтийг хангах, өдөр тутам авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг заасан хугацаанд Шуурхай штабын даргад танилцуулах;

4.1.7. Бусад багуудтай мэдээ, мэдээлэл солилцох, харилцан ажиллагааг хангах, дэмжлэг үзүүлэх.

### **4.2. Ажиллагаа-зохицуулалтын баг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:**

-Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, халдварын сэргийлэлтийн чиглэлээр:

4.2.1. Резидент эмч нарын нөөцийн судалгааг гаргаж, шаардлагатай газарт томилуулах саналыг Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төвд хүргүүлэх;

4.2.2. Тусгаарлан ажиглах байранд ажиллаж буй резидент эмч нарыг эмнэлгийн тусламж үйлчилгээний чиглэлээр мэргэжил арга зүйгээр хангах;

4.2.3. Тусгаарлан ажиглах байранд тусгаарлагдсан архаг хууч өвчтэй, эмнэлгийн тусламж, үйлчилгээ нэн шаардлагатай хүмүүсийн судалгааг гаргах, шаардлагатай иргэнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх ажлыг зохицуулах;

4.2.4. Халдварын тандалт шинжилгээ (хамгаалалтад авсан байр, орон сууц, гэрийн ажиглалтад байгаа иргэдийн), Нийслэлийн эрүүл мэндийн газраас зохион байгуулж байгаа Ковид-19-ийн ор бүхий эмнэлгийн тусламж үйлчилгээний мэдээллийг авч нэгтгэн тайлангийн хэсэгт тухай бүр хүргүүлэх;

4.2.5. Шинжилгээний цэгүүд болон вакцинжуулалтын цэгүүдийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг авч нэгтгэн тайлангийн хэсэгт тухай бүр хүргүүлэх;

4.2.6. Дүүргийн эмнэлгүүдийн лабораторын шинжилгээ (ПГУ)-ний талаарх мэдээллийг авч нэгтгэн тайлангийн хэсэгт тухай бүр хүргүүлэх .

-Татан авалтын чиглэлээр:

4.2.7. Гадаад улс орноос ирэх иргэдийн өргөдөл, хүсэлтийг он, сар, өдрөөр дарааллын дагуу эрэмбэлэх, хүндэтгэн үзэх шалтгаан, тавигдах шаардлагыг харгалзан татан авах хуваарь гаргаж [zasag.mn](http://zasag.mn) цахим хуудасны "Монгол Улс дахь COVID-19-ын талаар дэлгэрэнгүй мэдээ, мэдээлэл" хэсэгт нээлттэй байршуулах;

4.2.8.Тусгай захиалгат нислэгээр ирсэн иргэдийг тусгаарлан ажиглах байранд хуваарилах, тээвэрлэх, байрлуулах ажлыг зохион байгуулах;

4.2.9.Гадаад улс орноос ирж байгаа эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах шаардлагатай иргэдийг эрэмбэлэн тусгаарлах, тусламж үйлчилгээ үзүүлэх зохион байгуулалтын ажлыг хийх;

4.2.10.Тусгаарлан ажиглах байрны нөөц, эх орондоо ирэх хүсэлт гаргасан иргэдийн тоо, байршлыг харгалзан тусгай захиалгат нислэгийн хуваарь гаргах, батлуулах, татан авах ажиллагааг зохион байгуулах;

-Хил, хилийн боомт нэвтрүүлэх чиглэлээр:

4.2.11.Гадаад улс орноос авто болон төмөр зам, тусгай захиалгат нислэгээр ирсэн иргэдийг улсын хилээр хялбаршуулсан журмаар нэвтрүүлэх ажиллагааг зохион байгуулах;

4.2.12.Улс орны бүтээн байгуулалтад оролцох гадаадын инженер, техникийн ажилчдыг улсын хилээр нэвтрүүлэх ажиллагааг зохион байгуулах;

4.2.13.Олон улсын болон уул уурхайн бүтээгдэхүүн, экспорт, импортын ачаа тээврийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх ажиллагааг холбогдох байгууллагатай хамтран “Хилийн автозамын боомтоор улс хоорондын ачаа тээвэрлэлтийг зохион байгуулах түр журам”, “Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээвэрлэлтийн үйл ажиллагааг онцгой нөхцөл байдалд зохион байгуулах түр журам”-д заасны дагуу зохион байгуулах;

4.2.14.Монгол Улсын хилээр нэвтэрсэн зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний мэдээг нэгтгэн тайлангийн хэсэгт тухай бүр хүргэх.

-Иргэний болон ажиллах хүчний бүртгэл, чиглэлээр:

4.2.15.Халдварын сэжигтэй болон ойрын хавьтлын иргэд, гадаад, улс орноос татан авах болон тусгаарлагдсан иргэдийн овог, нэр, регистрийг Иргэний бүртгэлийн системээс шалгаж үнэн бодитой эсэхийг шүүж, баталгаажуулах, хувь хүний нууцыг хадгалах;

4.2.16.Улсын хэмжээнд тусгаарлан ажиглах байранд тусгаарлагдсан иргэд, үүрэг гүйцэтгэж буй эмч, алба хаагчдын бүртгэлийг хөтлөх, гэрийн ажиглалтад шилжих жагсаалтыг гаргах;

4.2.17.Гадаад улсад байгаа монгол иргэдэд холбогдох мэдээлэл хүргэх ажлыг Гадаад харилцааны яам, гадаад улс дахь Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газруудаар дамжуулан зохион байгуулах;

4.2.18.Дэд бүтэц, бүтээн байгуулалтад оролцох гадаадын ажиллах хүчний бүртгэл, судалгааг нэгтгэх;

4.2.19.Бүтээн байгуулалтад оролцох ажиллах хүчний тээвэрлэлт, тусгаарлалт, халдвар хамгааллын дэглэмийг сахиулахад мэргэжлийн заавар, зөвлөмжөөр хангах.

-Тусгаарлан ажиглах үйл ажиллагааг зохицуулах чиглэлээр:

4.2.20.Тусгаарлан ажиглах байрны судалгаа гаргах, зөвшөөрөгдсөн байранд иргэдийг хуваарилах, мэдээллийг шалгах;



4.2.21.Гадаад улсаас ирсэн болон ойрын хавьтлаар тусгаарлагдсан иргэдийн тоон болон дэлгэрэнгүй мэдээллийг нэгтгэх, шилжилт хөдөлгөөнд хяналт тавих, мэдээлэх;

4.3.22.Тусгаарлан ажиглах байранд байгаа шинжилгээнд хамрагдах иргэд, гэрийн ажиглалтад шилжих иргэдийн судалгааг гаргах;

4.3.23.Эхний болон давтан шинжилгээг авсан шуурхай арга хэмжээний багуудын үйл-ажиллагааны мэдээллийг нэгтгэх, хянах;

4.3.24.Иргэдийг тусгаарлан ажиглалтаас гаргах үйл явцад хяналт тавьж зохицуулах;

4.3.25.Тусгаарлах байрнаас гарах иргэдийг гэрийн ажиглалтад гаргах зөвшөөрлийг Улсын онцгой комиссын Шуурхай штабт хүргүүлэх;

4.3.26.Тандалт, хариу арга хэмжээний судалгаа, мэдээллийг нэгтгэж Улсын онцгой комиссын Шуурхай штабт хүргүүлэх

4.3.27.Тусгаарлан ажиглах байрны хэв журмыг сахиулах, аюулгүй байдлыг хангах, гарсан зөрчлийг таслан зогсоох;

4.3.28.Тусгаарлан ажиглах байр, гэр (амрах байр)-ийн эрүүл ахуйн халдвар хамгааллын дэглэмд хяналт тавих;

4.3.29.Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 20 дугаар тушаалаар баталсан “Тусгаарлан ажиглах үйл ажиллагааг зохицуулах түр журам”, “Гэр (амрах байр)-т тусгаарлан ажиглах үйл ажиллагааг зохицуулах түр журам”-ын дагуу үйл ажиллагааг зохион байгуулах.

#### **4.4. Бүс, орон нутаг, хариуцсан баг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:**

4.4.1.Засгийн газар, Улсын онцгой комиссын шийдвэрийг аймаг, нийслэлийн Онцгой комиссын шуурхай штабт хэрэгжүүлэх талаар мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, хяналт тавих;

4.4.2.Бүсийн төв, аймаг, нийслэлийн Онцгой комиссын шуурхай штабыг шаардлагатай мэдээллээр хангах;

4.4.3.Засгийн газар, Улсын онцгой комиссийн шийдвэрийн орон нутаг дахь хэрэгжилтийн талаар Шуурхай штабын даргыг мэдээллээр хангах;

4.4.4.Аймаг, нийслэлийн шуурхай штабаас ирсэн тайлан, мэдээг нэгтгэх.

#### **4.5.Хяналт-шинжилгээ, үнэлгээний баг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:**

4.5.1.Шуурхай штаб, Шуурхай штабын багуудын хийж гүйцэтгэсэн ажлын тайланд дүн шинжилгээ хийх, санал зөвлөмж боловсруулах;

4.5.2.Эрсдэл, тандалтын судалгаа, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, эрсдэлийн үнэлгээ бүрийн үр дүнг мэдээллийн санд оруулах;

4.5.3.Засгийн газар, Улсын онцгой комиссын шийдвэрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх;

4.5.4.Лавлах болон нээлттэй утас, цахим болон цаасаар ирсэн өргөдөл, санал, гомдол, шаардлага, зөвлөмжийн шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийх.

#### **4.6. Төлөвлөлтийн баг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:**

-Эрсдэлийн үнэлгээ, төлөвлөлтийн чиглэлээр:

4.6.1.Коронавируст халдварын эрсдэлийн үнэлгээг холбогдох байгууллагуудтай хамтран хийх;

4.6.2.Халдварын тархалтын түвшинд үндэслэн хариу арга хэмжээ зохион байгуулах санал гаргах;

4.6.3.Эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээний төлөвлөгөөг тодотгох, шаардлагатай нэмэлтийг тухай бүр оруулах;

4.6.4.Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр журам, заавар, төлөвлөгөөний төсөлд холбогдох байгууллагуудаас санал авч нэгтгэн боловсруулах;

4.6.5.Хариу арга хэмжээний багуудын нэгдсэн тайланд хийсэн дүн шинжилгээг үндэслэн шаардлагатай арга хэмжээг төлөвлөх;

4.6.6.Эрүүл мэндийн яам, Халдварт өвчин судлалын үндэсний төв болон бусад мэргэжлийн байгууллагуудын зөвлөмж, мэдээлэлд үндэслэн шаардлагатай арга хэмжээг төлөвлөх;

4.6.7.Шуурхай штабын багуудын сарын ажлын төлөвлөгөөг нэгтгэн Шуурхай штабын сарын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж батлуулах;

4.6.8.Хариу арга хэмжээний багуудын саналыг үндэслэн сургалтын хэрэгцээг тодорхойлж төлөвлөлтөд тусгах;

4.6.7.Хүн амын вакцинжуулалын зохион байгуулалт, үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийх, дүгнэлт, зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлэх;

-Мэдээ,судалгааны чиглэлээр:

4.6.8.Эрүүл мэндийн яам, Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс шаардлагатай мэдээллийг авах;

4.6.9.Батлагдсан тохиолдолын голомтын эцсийн халдваргүйжүүлэлт хийх объект, тоног төхөөрөмжийн тооцоо, судалгаа гаргах, халдваргүйжүүлэлт хийх ажлын зохион байгуулалтад хяналт тавих;

4.6.10.Холбогдох судалгааг гаргах.

#### **4.7. Нөөц, хангалтын баг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:**

-Эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, хүний нөөцийн чиглэлээр:

4.7.1.Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, хариу арга хэмжээнд шаардагдах хүний нөөц, эм, эмнэлгийн хэрэгсэл (урвалж, оношлуур, халдваргүйтгэлийн бодис, хувийн хамгаалах хувцас хэрэгсэл гэх мэт) техник, тоног төхөөрөмжийн судалгаа гаргаж, хэрэгцээг тодорхойлох, нөөцийн зураглал гаргах;

4.7.2.Улсын хэмжээний хариу арга хэмжээний чиглэл, цар хүрээ, шаардагдах нөөцийг харгалзан стандарт шаардлагад нийцсэн эм, эмнэлгийн хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжийн хангалтыг төлөвлөх;

4.7.3.Дайчлагдан ажиллах бие бүрэлдэхүүнийг тооцох, ажиллах заавар, журмаар хангах, сургалтад хамруулах, хяналт тавих;

4.7.4.Эмнэлэг, эмнэлгийн зориулалтаар ашиглах барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хүний нөөц зэрэг бүх төрлийн нөөцийг дайчлах стратеги боловсруулах.

-Хүнс, бараа материалын нөөцийн чиглэлээр:

4.7.5.Хүнсний нөөцийн судалгааг гаргах, тухай бүр тодотгох;

4.7.6.Ар тал, хангалтын /тээврийн хэрэгсэл, харилцаа холбоо, ус, дулаан хувцас, байр, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, шатах тослох материал, хоол хүнсний хангамж, эмнэлгийн тусламж, санхүү/ талаарх мэдээллийг холбогдох байгууллагуудаас авч нэгтгэх, тодотгох;

4.7.7.Гамшгаас хамгаалах улсын албадын хүч хэрэгслийн нөөцийн судалгаа гаргах, тодотгох;

4.7.8.Эмзэг бүлгийн иргэдийн судалгаа гаргах, шаардлагатай тохиолдолд хүнсний тусламж үзүүлэх төлөвлөлт, тооцоолол хийх, зохион байгуулах.

#### **4.8.Мэдээллийн технологи, харилцаа холбооны баг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:**

- Мэдээллийн технологийн чиглэлээр:

4.8.1 Коронавируст халдвар (Ковид-19)-тай тэмцэх зорилгоор хэрэгжүүлэх үйл ажиллагааны мэдээллийн солилцоо, боловсруулалт, түгээлтийн тогтолцоог сайжруулах, санал боловсруулах;

4.8.2.Шуурхай штабын үйл ажиллагаанд ашиглагдаж буй программ болон техник хангамж, интернэт, тусгай сүлжээ, файл серверийн хэвийн үйл ажиллагааг хангах, тэдгээрийн хэрэглэгчийн цахим мэдээлэлд хяналт тавих;

4.8.3.Коронавируст халдвар (Ковид-19)-тай тэмцэх зорилгоор хөгжүүлсэн төр, хувийн хэвшил, иргэний мэдээллийн системүүдийн уялдаа холбоог хангах, мэдээллийг анхдагч эх үүсвэрээс авах, мэдээллийн нэгдсэн урсгалыг бий болгох;

4.8.4.Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахалтай тэмцэх зорилгоор төрийн болон аж ахуйн нэгж, байгууллагын мэдээллийн системүүдийн хооронд мэдээллийг шуурхай солилцох боломжийг олгох шийдэл боловсруулах;

4.8.5.Коронавируст халдвар (Ковид-19)-тай тэмцэх ажлын талаарх тоон мэдээлэл, халдварын статистик мэдээллийг нэгдсэн байдлаар мэдээлэх дэд бүтцийг бий болгох;

4.8.6.Гэрийн ажиглалтад байгаа иргэдийг хянах байршил тогтоох системийн хэрэгжилтэд хяналт тавих, ижил төрлийн системүүдийг нэвтрүүлэх.

-Харилцаа, холбооны чиглэлээр:

4.8.7.Шуурхай штабын 1800-1105, Эрүүл мэндийн яамны 323002, Нийслэлийн эрүүл мэндийн үндэсний төвийн 119, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн

1800-0119, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 80086829, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 1800-2000, Зооноз, өвчин судлалын үндэсний төвийн 70284393, нийслэлийн Онцгой комиссын 324207 дугаарын утасны дуудлагын мэдээг өдөр бүр нэгтгэж, дүн шинжилгээ хийх;

4.8.8.Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын талаар олон нийтийг төөрөгдүүлэх, илт худал мэдээлэл цахим орчинд тархахаас сэргийлэх зорилгоор “Цахим орчинд зохицуулалт хийх журам”-ын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

4.8.9.Иргэдэд мэдээлэл өгөх, дуудлага хүлээн авах тусгай дугааруудыг нэгтгэх, төсөөтэй дугаарлалтыг нэгтгэх.

-Орон зайн дүн шинжилгээний чиглэлээр:

4.8.10.Коронавируст халдвар (Ковид-19)-ын нөхцөл байдлын талаарх орон зайн мэдээллийг бүрдүүлж, холбогдох мэдээллийн сангуудаас цахим хэлбэрээр татан төвлөрүүлж, дүн шинжилгээ хийх, үр дүн, зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, оновчтой шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх;

4.8.11.Халдварын нөхцөл байдлын талаарх мэдээллийг орон зайн мэдээллийн системүүдээр дамжуулан иргэн, хуулийн этгээдэд хүргэх;

4.8.12.Коронавируст халдвар (Ковид-19)-ын болон олон улсын хөл хориот бусад халдварт өвчний үед орон зайн мэдээллийн системийг ашиглан дүн шинжилгээ хийх, тандалтыг сайжруулах шийдэл боловсруулах.

#### **4.9. Захиргаа, санхүүгийн баг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:**

-Захиргаа, санхүү, аюулгүй байдлын чиглэлээр:

4.9.1.Шуурхай штабын дотоод ажлыг зохион байгуулах, аюулгүй байдлыг хангах;

4.9.2.Багийн ахлагчийн саналаар гишүүдийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх үүднээс ажиллах өдөр, цагийн хуваарийг гаргах;

4.9.3.Шуурхай штабын бүрэлдэхүүний ажилласан өдөр, цагийн тооцоог гаргах, холбогдох байгууллагад хүргүүлэх;

4.9.4.Шаардлагатай хүч хэрэгслийг тодорхойлох, татан оролцуулах, сэлгэн ажиллуулах;

4.9.5.Тусгаарлан ажиглах байранд тусгаарлагдсан иргэд, үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдын тоо, тусгаарлагдсан хоногийг тулгаж тооцоо нийлэх, тусгаарлах байрны төлбөр тооцоог хариуцсан байгууллагад баталгаажуулан хүргэх;

4.9.6.Шуурхай штабын үйл ажиллагааны зардал, төлбөр тооцоог шийдвэрлэх, зохион байгуулах;

4.9.7.Шуурхай штабын бүрэлдэхүүний хоол, унаа, томилт, халдваргүйжүүлэлт, дархлаажуулалтын асуудлыг шийдвэрлэх;

4.9.8.Хариу арга хэмжээнд шаардлагатай нөөцийг бүрдүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудлыг шийдвэрлүүлэх;

4.9.9.Багуудын үйл ажиллагааг хэвийн явуулах байр, бичиг хэрэг, эд зүйлс, техник тоног төхөөрөмжөөр хангах санхүүгийн асуудлыг шийдвэрлүүлэх.

-Өргөдөл гомдол, бичиг хэрэг, тайлан, архивын чиглэлээр:

4.9.10. Өргөдөл гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар мэдээ, мэдээллийг нэгтгэх, Хэвлэл, мэдээллийн хэсэг, Мэдээллийн технологи, харилцаа, холбооны багт тогтмол хүргүүлэх;

4.9.11. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн албан бичиг, өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, бүртгэх, холбогдох багуудад хуваарилах, шийдвэрлэлтийн бүртгэл хөтлөх, эзэн холбогдогчид эргэж мэдэгдэх;

4.9.12. Шуурхай штабын багуудын тайлан, мэдээг өдөр бүр авч нэгтгэх;

4.9.13.Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Шадар сайдын ажлын алба, Улсын онцгой комиссын Ажлын албанд Шуурхай штабын тайлан мэдээг нэгтгэж хүргэх.

4.9.14.Штабын үйл ажиллагааг баримтжуулах, хариу арга хэмжээний багуудаас гарсан тайлан мэдээ, судалгаа, баримт, материалыг архивлах;

### **Тав. Бусад зүйл**

5.1.Штабын бүрэлдэхүүн нь төрийн албан хаагчийн ёс зүйг баримтлан авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлнэ.



5.2.Штаб нь ажлын тусгай горимоор буюу уртасгасан цагаар ажиллана.

5.3.Штабын бүрэлдэхүүнд ажиллаж байгаа албан хаагчдын илүү цагаар ажилласан цагийн бүртгэлийг үндэслэн харьяалах байгууллагын удирдлагад тухайн ажилтанд холбогдох хууль тогтоомжид заасан нэмэгдэл хөлс, шагнал, урамшуулал олгуулах асуудлыг Шуурхай штабын дарга шийдвэрлэнэ.

5.4.Энэхүү журмыг зөрчсөн, үүргээ зохих ёсоор биелүүлээгүй албан хаагчид холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох саналыг тухайн алба хаагчийн харьяалах байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлнэ.


УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ШУУРХАЙ ШТАБЫН БҮТЭЦ

Улсын онцгой комиссын даргын 2021 оны 11 сар 17-ны өдөр дугаар тушаалын хоёрдугаар хэвсэг



Улсын онцгой комиссын даргын  
2021 оны ... дугаар тушаалын  
гуравдугаар хавсралт

УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ШУУРХАЙ  
ШТАБЫН БҮРЭЛДЭХҮҮН



Дарга

Ж.Чүлтэмсүрэн—Онцгой байдлын  
ерөнхий газрын тэргүүн дэд дарга,  
хурандаа

Шуурхай штабын орлогч

Б.Мандахгэрэл—Онцгой байдлын  
ерөнхий газрын Гамшгийн  
шуурхай удирдлагын газрын  
дарга, хурандаа

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ,  
тандалт-эрсдэлийн асуудал хариуцсан  
зөвлөх

М.Баттүвшин—Эрүүл мэндийн дэд  
сайд

Нийгэм-эдийн засгийн бодлогын  
асуудал хариуцсан зөвлөх

Г.Батхүрэл—Сангийн яамны Макро-  
эдийн засгийн бодлогын газрын  
дарга

Хяналт шалгалтын хэсэг:  
Багийн ахлагч:

С.Сүнчин—Мэргэжлийн хяналтын  
ерөнхий газрын Эрүүл мэнд,  
боловсрол, соёлын хяналтын  
газрын дарга

Гишүүд:

Т.Ихтамир—Хүний эрхийн  
үндэсний комиссын Гомдол,  
хяналт шалгалтын хэлтсийн дарга

Г.Ганхуяг—Эрүүл мэндийн яамны  
Хяналт, шинжилгээ, үнэлгээний  
газрын Хяналт-шинжилгээ,  
үнэлгээний хэлтсийн дарга

Ж.Батсайхан—Цагдаагийн ерөнхий  
газрын Олон нийтийн аюулгүй  
байдлыг хамгаалах хэлтсийн  
дарга, цагдаагийн хурандаа

Д.Баян-Эрдэнэ—Онцгой байдлын  
ерөнхий газрын Гал түймрийн  
улсын хяналтын хэлтсийн дарга,  
хурандаа

Хэвлэл, мэдээллийн хэсэг:  
Багийн ахлагч:

Ц.Мөнхбаатар—Шадар сайдын  
хэвлэл мэдээллийн асуудал  
хариуцсан зөвлөх

Гишүүд:

Д.Нарангэрэл—Эрүүл мэндийн  
яамны ахлах шинжээч

А.Алтанбагана—Онцгой байдлын  
ерөнхий газрын Гамшгаас

Шуурхай штабын нарийн бичгийн дарга:

Ажиллагаа, зохицуулалтын баг:

Багийн ахлагч:

Гишүүд:

Б.Дуламсүрэн–Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгаас урьдчилан сэргийлэх газрын Олон нийттэй харилцах төвийн дарга, хурандаа

Б.Энхмаа–Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгаас урьдчилан сэргийлэх газрын мэргэжилтэн, дэслэгч

Д.Хонгор–Онцгой байдлын ерөнхий газрын Эрүүл мэнд, сэтгэлзүйн тасгийн дарга, дэд хурандаа

М.Хаш-Эрдэнэ–Онцгой байдлын ерөнхий газрын Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн газрын ахлах мэргэжилтэн, дэд хурандаа

Г.Батхуяг–Онцгой байдлын ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын ахлах мэргэжилтэн, хошууч

А.Балжинням–Зэвсэгт хүчний жанжин штабын ажиллагааны удирдлагын газрын ахлах мэргэжилтэн, хурандаа

Л.Мөнхтүшиг–Гадаад харилцааны яамны Консулын газрын захирал

Ж.Дамдинсүрэн–Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгийн шуурхай удирдлагын газрын Тасгийн дарга, хурандаа

М.Цолмон–Халдварт өвчин судлалын үндэсний төвийн тархвар судлаач

А.Саранцэцэг–Халдварт өвчин судлалын үндэсний төвийн эмч

Э.Баярхүү–Гадаад харилцааны яамны Консулын газрын мэргэжилтэн

Н.Хонгор–Гадаад харилцааны яамны Дипломат ёслолын газрын мэргэжилтэн

О.Чингэсболд–Цагдаагийн ерөнхий газрын Олон нийтийн аюулгүй байдлыг хангах газрын чиглэлийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа



Ч.Бат-Эрдэнэ-Цагдаагийн  
ерөнхий газрын Эргүүл  
хамгаалалтын газрын эргүүл  
хамгаалалтын офицер, ахлах  
дэслэгч

Ж.Батсүх-Зам, тээврийн хөгжлийн  
яамны Авто тээврийн үндэсний  
төвийн хяналтын байцаагч

Д.Батдорж-Улаанбаатар төмөр  
зам хувь нийлүүлсэн  
нийгэмлэгийн хяналтын байцаагч

Г.Боорчи-Нийслэлийн тагнуулын  
газрын ажилтан, ахмад

М.Отгонбаяр-Нийслэлийн  
тагнуулын газрын орлогч дарга,  
хурандаа

Л.Очгэрэл-Гаалийн ерөнхий  
газрын зөрчилтэй тэмцэх, хэрэг  
бүртгэх газрын орлогч дарга

Д.Бүрэнцогт-Гадаадын иргэн  
харъяатын газрын ахлах  
мэргэжилтэн

Б.Баярсүрэн-Мэргэжлийн  
хяналтын ерөнхий газрын Буянт  
Ухаа боомт дахь хилийн  
мэргэжлийн хяналтын албаны  
эрүүл ахуй, халдвар хамгааллын  
хяналтын улсын ахлах байцаагч

С.Болормаа-Мэргэжлийн  
хяналтын ерөнхий газрын  
Экспорт, импорт зохицуулалтын  
хэлстийн эрүүл ахуй, халдвар  
хамгааллын хяналтын улсын  
ахлах байцаагч

Г.Ганзориг-Хил хамгаалах  
ерөнхий газрын Чөлөөт бүсийн  
хамгаалалт хариуцсан офицер,  
дэд хурандаа

Б.Баттулга-Хил хамгаалах  
ерөнхий газрын Шалган  
нэвтрүүлэх хэлтсийн Агаарын  
замын боомт хариуцсан офицер,  
ахмад

Д.Мөнхнайрамдал-МИАТ төрийн  
өмчит хувьцаат компанийн  
Нисэхийн аюулгүй байдал, онцгой  
байдал хариуцсан аудитор

Л.Отгонжаргал-ИНЕГ-ын Буянт-  
Ухаа олон улсын нисэх буудлын  
дэд захирал

Д.Батсүх–Үндэсний статистикийн хорооны хэлтсийн дарга

Д.Баярхүү–Эрүүл мэндийн хөгжлийн төвийн мэргэжилтэн

Х.Бунд-Очир–Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн

Б.Долгорсүрэн–Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж, бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн

Л.Мөнхбаатар–Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгийн шуурхай удирдлагын газрын мэргэжилтэн, хошууч

Д.Цэнджав–Нийслэлийн эрүүл мэндийн газрын мэргэжилтэн

В.Баярсайхан–Цэргийн төв эмнэлгийн шуурхай бүлгүүдийн удирдагч, хагалгааны тасгийн дарга, дэд хурандаа

М.Мөнгөнбаръяа–Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгийн шуурхай удирдлагын газрын мэргэжилтэн, ахмад

Б.Хишигбаатар–Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгийн шуурхай удирдлагын газрын мэргэжилтэн, хошууч

Я.Мөнхтулга–Улсын бүртгэлийн ерөнхий газрын ахлах архивч

Д.Ганболд–Нийслэлийн Аялал жуулчлалын газрын Хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

Э.Оргилцогцлох–Нийслэлийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн гамшгаас урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн

Төлөвлөлтийн баг:  
Багийн ахлагч:

Гишүүд:

Д.Баасансүрэн–Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгийн эрсдэлийн удирдлагын газрын дарга, хурандаа

Д.Баярболд–Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Эрүүл мэндийн хяналтын хэлтсийн дарга

Ц.Лхагвасүрэн–Онцгой байдлын ерөнхий газрын Дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлын хэлтсийн дарга, дэд хурандаа

З.Ундраа–Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээний дотоод аудитын газрын мэргэжилтэн

Г.Батсүрэн–Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Эрүүл ахуй, халдвар хамгааллын

Б.Энхтунгалаг–Нийслэлийн Эрүүл мэндийн үндэсний төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан

Б.Ариухантөмөр–Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн хуулийн зөвлөх

Л.Пүрэвдулам–Эрүүл мэндийн яамны хүний нөөцийн хөгжил хариуцсан мэргэжилтэн

А.Долгорханд–Эрүүл мэндийн яамны эрсдэлийн харилцаа, хариу арга хэмжээ хариуцсан ахлах мэргэжилтэн

Б.Мягмарсүрэн–Гамшгийн шуурхай удирдлагын газрын гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, дэд хурандаа

Л.Нямхүү–Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал амьтаны халдварт өвчний асуудал хариуцсан улсын ахлах байцаагч

Нөөц, хангалтын баг:  
Багийн ахлагч:

Ж.Энхзул–Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалт газрын Лиценз зөвшөөрлийн газрын дарга

Гишүүд:

Ш.Ариунзаяа–Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалт газрын Эм хангамжийн газрын мэргэжилтэн

Б.Батбаатар–Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн хөгжлийн бодлого, зохицуулалтын газрын мэргэжилтэн

Г.Наранчулуун–Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны

Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч

Л.Төмөр–Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Ашигт малтмал, газрын тосны газрын бүтээгдэхүүний хэлтсийн мэргэжилтэн

Д.Баярсайхан–Нийслэлийн Хүнс хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн

О.Билгүүн–Монголын улаан загалмай нийгэмлэгийн Гамшгийн удирдлагын багийн ажилтан

Мэдээллийн технологи,  
харилцаа холбооны баг:  
Багийн ахлагч:

Л.Энхбат–Харилцаа холбоо,  
мэдээллийн технологийн газрын  
Цахим хөгжлийн газрын дарга

Д.Содномрагчаа–Онцгой байдлын ерөнхий газрын Орон зай мэдээлэл, технологийн тасгийн дарга, дэд хурандаа

Гишүүд:

Ө.Гантулга–Үндэсний дата төвийн ҮТҮГ-ын Систем, нэгтгэлийн хэлтсийн дарга

Д.Очирпүрэв–Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн Систем төлөвлөлт, статистикийн албаны менежер

Т.Уламбаатар–Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгийн шуурхай удирдлагын газрын мэргэжилтэн, ахмад

Ж.Хатанзориг–Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл дүн шинжилгээний албаны Мэдээллийн технологийн хэлтсийн ахлах инженер, ахмад

О.Төмөртулга–Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгийн шуурхай удирдлагын газрын мэргэжилтэн, ахмад

Б.Анхбаяр–Тагнуулын ерөнхий газрын Мэдээллийн аюулгүй байдлын газрын Тусгай холбооны хэлтсийн инженер, ахмад

Б.Цэрэн-Очир–Эрүүл мэндийн яамны мэдээллийн технологи, систем нэвтрүүлэлт хариуцсан мэргэжилтэн

Б.ТүмэнбаярсНийслэлийн Мэдээллийн технологийн газрын хэлтсийн дарга

С.Долгорсүрэн–Харилцаа холбооны зохицуулах хорооны Зохицуулалтын бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга

Д.Эрдэнэцэцэг–Мэдээлэл холбооны сүлжээТӨХХК-ийн Стратеги төлөвлөлтийн газрын ажилтан

Д.Лхагва-Өлзий–Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн Систем төлөвлөлт, статистикийн албаны ахлах мэргэжилтэн

Г.Цогтдэлгэр–Нийслэлийн мэдээллийн технологийн газрын Орон зайн мэдээллийн сангийн мэргэжилтэн

А.Сумъяа–Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Орон зайн мэдээлэл технологийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Ц.Бямбацогт–Онцгой байдлын ерөнхий газрын Орон зай мэдээлэл, технологийн тасгийн мэргэжилтэн, ахмад

П.Нямдаваа–Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Кадастрийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Ц.Эрдэнэмөнх–Үндэсний статистикийн хорооны Мэдээллийн технологийн газрын ахлах референт

С.Отгонжаргал–РТУС, УТҮГ-ын Хэвлэл мэдээллийн ажилтан

Хяналт-шинжилгээ, үнэлгээний баг:

Багийн ахлагч:

Ч.Гантулга–Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга

Гишүүд:

Д.Одгэрэл–Боловсрол, шинжлэх ухааны яамны Инновацийн ехнологийн газрын дарга

Ж.Дамбадаржаа–Онцгой байдлын ерөнхий газрын Дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлын газрын ахлах мэргэжилтэн, хошууч

П.Мөнхбат–Гамшиг судлалын хүрээлэнгийн Аюулгүй байдлын үнэлгээний төвийн дарга, хошууч

Орон нутгийн бүс хариуцсан баг:

Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны хэлтсийн дарга Д.Бат-Эрдэнэ, дэд хурандаа

Ч.Мөнхбат–Онцгой байдлын ерөнхий газрын Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн газрын хэлтсийн дарга, хурандаа

Т.Билгүүн–Онцгой байдлын ерөнхий газрын Бодлого зохицуулалт, хамтын ажиллагааны газрын мэргэжилтэн, ахлах дэслэгч

Г.Энхцолмон–Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны хэлтсийн мэргэжилтэн, хошууч

Захиргаа, санхүүгийн баг:

Багийн ахлагч:

Г.Бат-Эрдэнэ–Онцгой байдлын ерөнхий газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, хурандаа

Б.Сайнжаргал–Сангийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн

А.Жандаг–Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын мэргэжилтэн, ахмад

Д.Байгальмаа–Онцгой байдлын ерөнхий газрын Ар тал хангалт, хөрөнгө оруулалтын газрын мэргэжилтэн, ахлах дэслэгч

Гишүүд:

С.Алтангэрэл–Онцгой байдлын ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын мэргэжилтэн, дэслэгч

Б.Тунгалаг–Нийслэлийн Аврах  
анги-105-ийн бичиг хэргийн  
ажилтан, ахлах ахлагч

Э.Оюунгэрэл–Гамшиг судлалын  
хүрээлэнгийн химич, ахлах  
дэслэгч

Б.Нямбат–Онцгой байдлын  
ерөнхий газрын Захиргааны  
удирдлагын газрын Сургалтын  
хэлтсийн мэргэжилтэн, ахлах  
дэслэгч

Т.Мөнхчимэг–Онцгой байдлын  
ерөнхий газрын Захиргааны  
удирдлагын газрын архивын  
эрхлэгч, дэслэгч

Б.Алтан-Очир–Үндэсний аврах  
бригадын мэргэжилтэн, ахмад

Ш.Дашцэдэн–Онцгой байдлын  
ерөнхий газрын Гамшгийн  
шуурхай удирдлагын газрын  
ахлах мэргэжилтэн, дэслэгч

Д.Төмөрчөдөр–Онцгой байдлын  
ерөнхий газрын Гамшгийн  
шуурхай удирдлагын газрын  
мэргэжилтэн, ахмад

Т.Зориг–Онцгой байдлын ерөнхий  
газрын Бодлого зохицуулалт,  
хамтын ажиллагааны газрын  
мэргэжилтэн, ахлах дэслэгч

О.Мөнхбаяр–Онцгой байдлын  
ерөнхий газрын Гал түймэртэй  
тэмцэх газрын мэргэжилтэн,  
хошууч

Э.Золзаяа–Үндэсний аврах  
бригадын аврагч, холбоочин,  
ахлах ахлагч

П.Мөнгөншагай–Үндэсний аврах  
бригадын аврагч, холбоочин,  
ахлах ахлагч

Ц.Бямбасүрэн–Үндэсний аврах  
бригадын аврагч, холбоочин,  
ахлах ахлагч

Д.Саранчимэг–Үндэсний аврах  
бригадын аврагч, холбоочин,  
ахлах ахлагч

Б.Батбаатар–Үндэсний аврах  
бригадын аврагч, холбоочин, дэд  
ахлагч

Нислэгийн үед Буянт-Ухаа хилийн  
боомтод ажиллах бүрэлдэхүүн:

Н.Шинэжаргал–Үндэсний аврах  
бригадын аврагч холбоочин,  
ахлах ахлагч

Б.Дүүмаам–Уул уурхайн аврах  
ангийн аврагч, ахлах ахлагч

Э.Отгонбаяр–Уул уурхайн аврах  
ангийн аврагч, дэд ахлагч

Б.Отгонцэцэг–Буянт-Ухаа боомт  
дахь Хилийн мэргэжлийн  
хяналтын албаны дарга

Б.Билгээ–Хилийн цэргийн 0218-р  
ангийн штабын дарга, хошууч

О.Болдбаатар–Тагнуулын ерөнхий  
газрын тасгийн дарга, дэд  
хурандаа

М.Уянга–Тагнуулын ерөнхий  
газрын ахлах ажилтан, хошууч

Ц.Одсүрэн–Буянт-Ухаа дахь  
Гаалийн газрын хяналт шалгалтын  
албаны дарга

Д.Ганбат–Буянт-Ухаа дахь  
цагдаагийн хэлтсийн орлогч дарга,  
дэд хурандаа

З.Даваасүрэн–Гадаадын иргэн  
харъяатын газрын Агаарын замын  
боомтын газрын дарга

М.Гүен–Иргэний нисэхийн ерөнхий  
газрын Буянт-Ухаа Олон Улсын  
Нисэх буудлын аюулгүй байдал,  
хамгаалалтын албаны дэд дарга

Д.Батцэнгэл–Иргэний нисэхийн  
ерөнхий газрын Буянт-Ухаа Олон  
Улсын Нисэх буудлын  
Үйлдвэрлэлийн ерөнхий  
зохицуулагч

С.Батсүх–МИАТ ТӨХК-ийн зорчигч  
бүртгэлийн хэлтсийн дарга